

2018.10.03



Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг Эрүүл мэндийн статистик мэдээлэл

2018 ОНЫ ЭХНИЙ 09 САРЫН БАЙДЛААР

Мандалговь хот

Дундговь нэгдсэн эмнэлэг

Статистик мэдээлэл технологийн албанаас эрхлэн гаргав.

E-mail: emneleg@dundgovi.gov.mn

Факс: 976-7059-3991

Утас: 7059-3991

**Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд
/2017, 2018 оны эхний 9 сарын байдлаар /**

№	Үзүүлэлт	Нэгж	2017он	2018он	Өсөлт бууралт
1	Төрсөн эх	Бодит тоо	583	637	54
2	Амьд төрсөн хүүхэд	Бодит тоо	587	644	57
3	Амьгүй төрсөн хүүхэд	Бодит тоо	2	2	0
		1000 нийт төрөлтөд	3.4	3.1	-0.3
4	Эхийн эндэгдэл	100000 амьд төрөлтөд	0	0	0
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4нас 364 хоног/	Бодит тоо	2	2	0
		1000 амьд төрөлтөд	3.4	3.1	-0.3
6	Нялхасын эндэгдэл/0-364 хоног/	Бодит тоо	2	2	0
		1000 амьд төрөлтөд	3.4	3.1	-0.3
	Нярайн эндэгдэл /0-28 хоног/	Бодит тоо	2	2	0
		1000 амьд төрөлтөд	3.4	3.1	-0.3
		Нялхасын эндэгдэлд эзлэх хувь	100	100	0.0
	Нярайн эрт үеийн эндэгдэл/0- 6 хоног/	Бодит тоо	2	1	-1
		1000 амьд төрөлтөд	3.4	1.6	-1.8
		Нялхасын эндэгдэлд эзлэх хувь	100	50.0	-50.0
		Нярайн хожуу үеийн эндэгдэл/7- 28 хоног/	Бодит тоо	0	1
		1000 амьд төрөлтөд	0.0	1.6	1.6
		Нялхасын эндэгдэлд эзлэх хувь	0.0	50.0	50.0
	7	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	4	3
1000 нийт төрөлтөд			6.8	4.6	-2.2
8	Нийт нас баралт	Бодит тоо	13	30	+17
9	Эмнэлэгт нас баралт	Бодит тоо	13	30	+17
10	Хоног болоогүй нас баралт	Бодит тоо	6	16	+10
		хувь	46.1	53.3	7.2
11	Эмнэлэгт хэвтсэн	Бодит тоо	4247	4575	328
12	Эмнэлгээс гарсан	Бодит тоо	4263	4627	4
13	Нийт ор хоног	Бодит тоо	30641	32882	-2241
14	Дундаж ор хоног	Бодит тоо	7.2	7.1	-0.1

Эх хүүхдийн эрүүл мэнд


Төрөлт

Төрөлт нэгдсэн эмнэлгийн хэмжээнд 2018 оны эхний 9 сарын байдлаар 637 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 54 төрөлтөөр буюу 9.2 хувиар өссөн байна. Төрсөн эхчүүдийн 547 нь буюу 85.8 хувь нь эмчийн хяналтын үзлэгт зургаа ба түүнээс дээш удаа хамрагдсан байна.


Гэрийн төрөлт бүртгэгдээгүй байна.

Үр хөндөлтийн 46 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүний 5 тохиолдол нь 20 хүртлэх нас байна. Нийт төрсөн эхчүүдийн 22.3 хувь нь мэс заслын аргаар төрсөн байна.

2018 оны эхний 9 сарын төрсөн эхийн тоо



2018 оны 9 сарын байдлаар төрсөн эхчүүд насны ангилалаар



Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл

2018 оны 9 сарын байдлаар нийт төрсөн эхчүүдээс жирэмсэн үеийн хүндрэлтэй 88 эх бүртгэгдсэн бөгөөд нийт төрөлтийн 13.8 хувийг эзэлж байна.


Жирэмсэн үеийн хүндрэлийн 68.4 хувийг жирэмсэн үеийн даралт ихсэх эзэлж байна (O14.0)

Төрөх үеийн хүндрэлтэй 18, нийт төрсөн эхчүүдийн 2.9 хувь,

төрсний дараах хүндрэлтэй 4 эх байгаа бөгөөд нийт төрсөн эхчүүдийн 0.6 хувийг эзэлж байна.

Зураг -3

Жирэмсэн, төрсөн , төрсний дараах хүндрэл 2017-2018 он 9 сарын байдлаар



Хүүхдийн эрүүл мэнд

2018 оны 9 сарын байдлаар нэгдсэн эмнэлэгт 644 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 57 хүүхдээр буюу 8.8 хувиар өсчээ. Амьд төрсөн хүүхдийн 343 буюу 53.6 хувь нь хүү, 301 буюу 46.7 хувь нь охин байна. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 99.0% байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 2.8 % буюу 18 тохиолдол 2500 граммаас доош жинтэй төржээ.

Зураг -4


Нийт төрсөн нярай, 1цагийн дотор хөхөө амалсан



Нялхсын эндэгдэл :


2018 оны 9 сарын байдлаар нэгдсэн эмнэлэгт 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 1000 амьд төрөлтөд 3.1 промилль байна. Нярайн эрт үеийн эндэгдэл буюу 0-6 хоногтой 1, хожуу үеийн буюу 7-28 хоногтой -1, **Үндсэн онош: Төрөлхийн 12 хуруу гэдэсний битүүрэл , цутгалан гэдэсний төрөлхийн нарийсал**

2017,2018он нярайн нас баралт 1000 амьд төрөлтөд



Амбулаторийн тусламж үйлчилгээ:


2018 оны эхний 9 сарын байдлаар нийтдээ 54940 үзлэг хийгдсэн бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 22.7 % , идэвхитэй хяналт 11.6% байна. Нийт үзлэгт хүйсийн хувьд 17947 буюу 32.6 % нь эрэгтэй 36992 буюу 67.3% нь эмэгтэй байна




Стационарын тусламж үйлчилгээ

2018 он энхий 9 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт **4575** хүн хэвтэн эмчлүүлж **4627** хүн эмнэлгээс гарч нийт ор хоног орны хөдөлгөөнөөр **32882**, дундаж ор ор хоног 7.1 байна

Эмнэлэгт хэвтсэн , эмнэлгээс гарсан хүний тоо




Өвчтөн илгээх хуудсаар ирж хэвтсэн хүний тоо, өвчтөн илгээх хуудсаар ирж үзүүлсэн хүний тоо/2017, 2018 оны 9 сарын байдлаар/



Нас баралт

2018 оны эхний 9 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт ,эмнэлгийн нас баралтын 30 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 17 тохиолдолоор нэмэгдсэн байна .

Нас баралт : 2017, 2018 оны эхний 9 сар нас баралт, хүйсээр



Нас баралтын түвшин 1000 хүн амд 0.6 байгаа бөгөөд , нийт хэвтэн эмчлүүлэгсэдийн 0.6 хувийг эзэлж байна.Нийт нас баралт нь хүйсийн хувьд 20 тохиолдол буюу 66.6 хувь нь эрэгтэй , 10 тохиолдол буюу 33.3% эмэгтэй байна

Хоног болоогүй нас баралтын 16 тохиолдол үүнээс 8-24 цагийн дотор 9 тохиолдол бүртгэгдсэн байна .Нийт нас баралтын **53.3 хувь** нь хоног болоогүй бөгөөд хэвтэн эмчлүүлэгсэдийн 0.3 хувийг эзэлж байна.

Эмгэг судлалын шинжилгээ


Эмгэг судлалын задлан шинжилгээнд 12 тохиолдолд орж 40.0 хувь, оношийн зөрөө 2

6.6 % үндсэн оношоор зөрсөн байна. Эсийн шинжилгээ **1802** бүртгэгдсэн.

Хорт хавдар, гадны шалтгаант нас баралт

2018 оны эхний 9 сарын байдлаар хорт хавдрын нийт 9 нас баралт бүртгэгдсэн бөгөөд нийт нас баралтын 30.0% эзэлж байна. Осол гэмтэл гадны шалтгаант 3 тохиолдол бүртгэгдсэн нь зам тээврийн осол-1, бусад осол-1, бусдад хорлогдож нас барсан -1 тохиолдол бүртгэгдсэн байна. нийт нас баралтын 10%-г осол гэмтлийн нас баралт эзэлж байна.

2017,2018 оны хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант нас баралт бодит тоогоор



Нас баралт ,ТАСГИЙН НЭР, ӨОУА-10


д/д	Тасгийн нэр	Хоног болоогүй	8-24 цагийн дотор	ӨОУА-10
1	Эрчимтэмчилгээ	45минут		K28.4
2	Эрчимт эмчилгээ			C22.0
3	Эрчимт эмчилгээ	35минут		I25.2
4	Эрчимт эмчилгээ			Q41.2
5	Эрчимт эмчилгээ			K74.0
6	Эрчимт эмчилгээ	1цаг		V43.0
7	Эрчимт эмчилгээ	2цаг		X45.0
8	Эрчимт эмчилгээ			E11.0
9	Эрчимт эмчилгээ			C25.0
10	Хөнгөвчлөх	9цаг	+	A41.8
11	Хөнгөвчлөх			C22.9
12	Хөнгөвчлөх			C34.0
13	Хөнгөвчлөх			C53.0
14	хөнгөвчлөх	12цаг	+	C22.0
15	Төрөх			Q41.2
16	Сүрьеэ			A19.8
17	Мэдрэл	16цаг	+	I61.0
18	Мэдрэл	11цаг	+	I61.5
19	Дотор	10цаг	+	K74.0
20	Дотор			I21.0
21	Дотор	7цаг		E11.0
22	хөнгөвчлөх	18цаг	+	C67.0
23	Эрчимт эмчилгээ	18цаг	+	A 41.8
24	Эрчимт эмчилгээ	1цаг		X 99
25	Дотор			E 10.0

26	Дотор	18цаг	+	K70.2
27	дотор			K74.0
28	Эрчимт эмчилгээ			I22.8
29	Эрчимт эмчилгээ	3цаг		C77.0
30	Эрчимт эмчилгээ	1цаг		C34.0

Халдварт бус өвчлөл 2018 оны 9сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт халдварт бус өвчлөлийн 9507 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 6213 буюу 63.3 хувь нь шинэ өвчлөл, 6213 буюу 34.6% нь хуучин өвчлөл бүртгэгдсэн байна.

Хорт хавдрын өвчлөлийн 45 буюу нийт халдварт бус шинэ өвчлөлийн 0.5 хувь , осол гэмтлийн өвчлөлийн 244 шинэ тохиолдол бүртгэгдэж нийт халдварт бус шинэ өвчлөлийн 2.5 хувийг эзэлж байна

Халдварт бус өвчлөл 2017, 2018 оны эхний 9 сар



0-5 хүртлэх насны хүүхдийн томуу, томуу төст өвчин, халдварт бус суулгалт



Осол гэмтэл гадны шалтгаант өвчлөл

2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 244 осол гэмтлийн өвчлөл бүртгэгдсэн байна.

Хүйсийн байдлаар авч үзвэл 73.0% нь эрэгтэй 27.0% нь эмэгтэй байна. Нийт осол гэмтлийн өвчлөлөөс гэмтэл авах үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол 15.5%-г эзэлж байна.

Нас баралтын 3 тохиолдол бүртгэгдсэн нь зам тээврийн осол-1, бусад осол -1, бусдад хорлогдсон-1 байна


Халдварт бус өвчлөлөөс осол гэмтлийн өвчлөлийг шалтгаанаар авч үзвэл:

Осол гэмтлийн өвчлөл	2017	2018
нийт	357	244
эр	257	173
эм	100	71
<i>согтууруулах ундаа хэрэглсэн</i>	74	38
<i>Зам тээврийн осол/V00-V99/</i>	163	99
<i>Бүх төрлийнуналт/W00-W19/</i>	64	34
<i>Амьгүй механик хүчинд өртөх/W20-W49/</i>	16	51
<i>Амьтай механик хүчинд өртөх/W50-W64/</i>	13	7
<i>Усанд унаж живэх/W65-W74/</i>	2	2
<i>Бусад тодорхойгүй осол /W75-W84/</i>	2	1
<i>Түлэгдэлт /W85-X19/</i>	15	14
<i>Хорт ургамал амьтанд өртөх/W85-X19/</i>	1	
<i>Байгалийн хүчинд өртөх /X30-X39/</i>		
<i>Амиа хорлохыг завдах /X60-X84/</i>	1	4
<i>Хүчирхийлэл /X85-Y09/</i>	80	32

Түргэн тусламжийн дуудлага

Нэгдсэн эмнэлэгт 2018 оны 9 сарын байдлаар 4802 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 0.9 хувийг алсын, 3.1 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна.Өмнөх оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага 161дуудлагаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна

Нийт дуудлага, осол гэмтэл, алсын дуудлага/2017,2018 оны 9 сарын байдлаар/



Мэдээ нэгтгэсэн: Статистикч их эмч
Хянасан:Ерөнхий эмч

Б.Дариймаа
Х.Жаргал

